

Монгол дахь “Үкиё-э буюу модон бараар хэвлэсэн зургийн тухай лекц үзүүлбэр”

10 дугаар сарын 17-ны өдөр Японы Уламжлалт модон барын арга барилыг хадгалах “Адачи” сангаас “Японы Үкиё-э буюу модон бараар хэвлэсэн зургийн тухай лекц, үзүүлбэр” нэртэй арга хэмжээг зохион байгуулах бөгөөд арга хэмжээний хамтран зохион байгуулагчаар Япон улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яам, ивээн тэтгэгчээр Хаан банк, Япон сан тус тус оролцож байна. Уг арга хэмжээний үеэр “Канавагийн агуу давалгаа” зургийг бодитоор хэвлэх үзүүлбэрийг үзүүлж, үкиё-э зургийн талаар тайлбар хийх болно.


- 2014 оны 10 сарын 17-ны өдөр, 12 цагт
ХААН банкны төв байрны “Red Ger” галерейд



Зураг 1 Бодитоор хэвлэж үзүүлэх үкиё-э зураг “Канавагийн агуу давалгаа”



Зураг 2 Үзүүлбэрийн явц болон үкиё-э зургийн талаар тайлбарлаж буй нь



Зураг 3 Бодитоор үкиё-э зургийг хэвлэж буй нь

Тайлбарлагч:

Овог нэр: Мэгүри НАКАЯМА

Төрсөн огноо: 1974 оны 2 сарын 18 өдөр

- Хитоцүбаши их сургуулийн хуулийн факультетийг төгссөн
- Дүрслэх урлагийн музей (Улсын Токио музей, Канагава мужийн түүхийн музей, Хирошигэ дүрслэх урлагийн музей), их дэлгүүр зэрэг газарт Үкиё-этэй холбогдолтой арга хэмжээг зохион байгуулагч, арга хэмжээнд үзүүлбэрийн тайлбарлагч
- Япон сангийн хүсэлтээр богино хугацааны мэргэжилтэн урих хөтөлбөрт хамрагдан гадаад уран бүтээлчдэд модон барын арга барилын тайлбар хийж байсан
- Токио хотын Аяллын сангийн хүсэлтээр Австрийн сэтгүүлчдэд модон барын арга барилын танилцуулга болон үзүүлбэрийн тайлбар хийж байсан

Хэвлэгч:

Овог нэр: Ёшио КЁОСО

Төрсөн огноо: 1980 оны 7 сарын 7 өдөр

- Такүшоқү их сургуулийн төгсөлтийн дараах сургуулийг Инженерийн факультетийн Визуал харилцааны дизайны мэргэжлээр төгссөн
- Адачи модон бар судлалын институтэд хэвлэгчийн суралцагчаар орж байсан
- Одоо үкиё-э зургийн хэвлэгч хийдэг ба үкиё-э зургийн хуулбар, орчин цагийн бүтээлийг бүтээх ажиллагаанд оролцдог
- Дүрслэх урлагийн музей (Улсын Токио музей, Улсын түүх, үндэстний музей, Оотагийн нэрэмжит дүрслэх урлагийн музей), их дэлгүүр зэрэг газарт Үкиё-этэй холбогдолтой арга хэмжээг зохион байгуулагч
- Олон нийтэд зориулсан үзүүлбэр, семинарын хэвлэгч багш
- Тамхи ба давсны музейн модон барын ангийн хэвлэгч багш
- Сан Диего их сургуулийн зуны сургуулийн модон барын ангийн хэвлэгч багш
- Уламжлалт модон барын арга барилыг хадгалах “Адачи” сангаас зохион байгуулдаг модон барын ангийн хэвлэгч багш